

“Бодончир мунхаг” нэрийн тухайд

Докторант А.Энхбат /ШУТИС.ХуУС./

МНТ-ны 17-р зүйлд “Бодончир мунхаг” хэмээх нэр анхлан гарна. “Бодончар барагцаалбал Х зууны эцсээр байсан хүн бөгөөд эрэлхэг зоригтой хүн бөгөөд монгол аймгийг захирч байжээ”.¹ “Бодончар ба түүний салаа мөчирөөс угсаалсан хэмээх Ноёндай, Барулас, Адархин, Уруд, Мангуд, Тайчуд, Оронар, Хонхотон, Арулад, Сөнид, Хабтурхис, Хэнигис, Жүрхи, Хиад боржигон овгууд цөм нэг яс цусны холбоотон буюу ургууд хэмээн өрсдийгөө тооцно. Гэтэл Бодончарын угсааны эл овгууд бусдыг харилцан гадуурхан байсан баримт олон буй.”² Ийнхүү монгол угсаатны голлох овгуудыг үндэслэгчийн нэрийг судлаачид олон янзаар тайлбарласан байдаг. Жамбалдоржийн <<Болор толь>>-д Буданцар, Цахар гэвш Лувсанцүлтэм сүмбүд³ бичихдээ Буданчар⁴ гэх мэтээр монгол сурвалжуудад Бодончирийн нэрийг янз бүрээр бичдэг. Гэхдээ уг нэрийн Бод буюу Буд язгуур, чир буюу цар, чар дагавар нь ижил гэж ойлгогдож байна. Энэ өгүүлэлд Бодончир нэрийг Бодон - Чир гэж салган авч үзлээ.

Бодончир мунхаг хэмээх нэрийг дорвитой судалсан эрдэмтэн бол судлаач У.Эрдэнэбат юм.⁵ Тэрээр олон эрдэмтдийн санал, түүхэн сурвалжуудыг нягтлан “... Чингис хааны элэнц дээдэс Бодончар-Мунхагийн нэр нь зарим судлаачдын үздэгчлэн хээр бутанд олдсон эцэггүй хүүхэд гэсэн утгатай Бутанцар гэх нэр биш, харин дайсныхаа өөдөөс эргэх буцахаа умартан мунхагаар хадран довтлогч зэрлэг бодон гахай лугаа адил эрэлхэг зоригтон /дайчин баатар/ гэсэн эртний уламжлалт нэр мөн байна”⁶ гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Эрдэмтэн Ш.Гаадамба агсан “Бодон” нэрийн талаар “Бодончарын олзлон авч эхнэрээ болгосон хээлтэй эмийн нэр Бодон буюу Бөдүн гэж байгаа нь нэн сонирхолтой. Энэ үг бол бидний бодож байгаагаар бас л хүний тусгайлсан нэр биш. Энэ бол овгийн толгойлогч анчин баатар эмэгтэйг хэлдэг ерөнхий нэр байсан бололтой”⁷ гээд Нанайчуудын үлгэрт гардаг баатар хүүхэн Пүдинийг “... монголын <<будан>>, <<бөтүн>>, <<будан>>, <<бодон>> гэсэн үгсийн эртний жинхэнэ утгыг илтгэж байгаа боловуу гэж бодож байна. Энэ үнэн бол монголын аман зохиолд олонтаа дайралддаг <<Эзэн улаан бодон>>, (<<Талын>>) Шар бодон гэх зэрэг туульсын баатрын нэр бол угтаа <<эр хүний (маягийн) хувцастай баатар анчин эмэгтэйн>> тухай үлгэрүүд байжээ”⁸ хэмээжээ. Эрдэмтэн Гаадамба агсан Бодончирийн авсан эмийн тухай мэдээг Саган сэцний Эрднийн товч, Галдан туслагчийн Эрдэнийн эрхи, Хөх дэвтэр зэрэг сурвалжуудаас авсан байна. Тэгвэл дээрх сурвалжуудын эх үндэс болсон МНТ-ны 38-р зүйлд “*bodoncar alginei gayulzu dunda kegelitei eme-ji barizu*”⁹ хэмээсэнийг эрдэмтэн Ц.Дамдинсүрэн орчин цагийн монгол хэлнээ “Бодончар тэргүүлэн явж нэгэн жирэмсэн эмийг барьж”¹⁰ гэж хөрвүүлжээ. Эндээс харахад Бодончирийн барьсан эм, эмэгтэй тэр тусмаа жирэмсэн байсан нь мэдэгдэж байна. Тиймээс түүнийг эр хүний дүрд хувирсан баатар эмэгтэй гэхэд эргэлзээ төрж байна. Монгол туульсийн Эзэн улаан Бодон, Талын шар Бодон, Талын хар Бодон, Тэрхэн шар Бодон, Цахар Бодон хаан гэх зэрэг батрууд ихэвчлэн өөртөө тохирох хатан, эхнэр хайн тэмцэж байгаагаар дүрслэгдсэн байдаг нь тэднийг эмэгтэй байсан гэдгийг үгүйсгэж байна. Тэгээд ч “Халх болон ойрдын баатарлаг

¹ Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг” УБ. 1990 он. 22-р тал

² Г.Гонгор. “Халх товчоон”. II. УБ. 1978 он. 2-р тал

³ Хуучирсан бүрэн зохиол. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” УБ. 1968 он. 496-р тал

⁴ Г.Сүхбаатар. “Монгол Нирун улс”. УБ. 1992 он. 137, 138-р тал /дам ишлэв/

⁵ У.Эрдэнэбат. “МНТ-ны Бодончар-Мунхаг нэрийн учир” “Corea-Mogol joint stusents-4” Seoul, 1995

⁶ У.Эрдэнэбат. “МНТ-ны Алан-гоа эхийн домгийн учир” УБ. 1997 он. 84-р тал

⁷ Ш.Гаадамба. “МНТ судлалын зарим асуудал” УБ. 1990 он. 78-р тал

⁸ Мөн тэнд

⁹ Б.Сумъяабаатар. “МНТ-ны үсгийн галиг”. УБ. 1990 он. 37-р тал

¹⁰ “МНТ” УБ. 1990 он. (4 дэх удаагийн хэвлэл). 30-р тал

тууль нь эцгийн эрхт овгийн байгууллын үед анх үүссэн.”¹¹ Гэхдээ эрдэмтэн Гаадамба агсны “Манай туульсын баатрын <<бодон>> гэдэг нэр үүний нэг адил анх эмэгтэй баатрын нэр байгаад дараа нь эрэгтэй баатарт шилжсэн байхаас зайлахгүй”¹² гэсэн дүгнэлтийг анхааран үзүүштэй юм.

Рашипунцагийн Болор эрхид “... Бодот тэнгэрийг үзсэний шалтгаанаар /зүүдэндээ А.Э/ олсон бөлгөө хэмээн Бодончар хэмээх нэр өгөв”¹³ гэснийг эрдэмтэн С.Дулам “Бодончир нэрийн гарлыг “бод”, “бодтой” гэсэн үгнээс үүсэлтэй гэж үзсэн нь сонин юм”¹⁴ гэж тэмдэглэжээ. Буриадын зарим овогийн гарал үсэлтэй холбогдох ардын аман зангиас өгүүлбэрт “... Хурц хөвүүндээ худай, Бодолтой хөвүүндээ бодонгууд ... тус тус нэр өгч”¹⁵ байсан нь дээрх санааг улам бататгаж байна.

Талын хар Бодон хэмээх баруун монгол ардын туульд “Довон Хар бөх дайн дайсангүй байна гэж найр хийж байгаад үр хүүхэдгүй гэж гунихран уйлсан учир талын хар Бодон гэдэг хүүг хадам болох хаан хурмаст, хар луст ээж нь илгээв”¹⁶ гэж өгүүлсэн байна. Эндээс харахад эртний монголчуудын дунд тэнгэрээс гаралтай хэмээгдсэн бодол ухаантай төрсөн хөвгүүдийн бодол ухааныг бэлгэдэн Бодон язгуурт нэр өгдөг байжээ гэсэн дүгнэлт хийж болно.

Бодон нэрийн ард буй чар буюу чир дагаварын тухай авч үзье. Судлаач Ю.Болдбаатар “... “Чур” гэдгийг эртний Түрэг (VII-VIII), Уйгар (VIII-IX) үеийн сурвалжит язгууртны цол чимэг ... ”¹⁷ хэмээгээд “Чур” цолтой 20 түрэг угсаатан язгууртны нэрийг хүснэгтэнд жагаасан байна.

Түрэг судлаач Ц.Баттулга “Монголчуудын бага балчир хүүхдийг дорд үзэн дорой санах, хэлэх нь учир бэлгэдэл, ёс заншилд харш тул харь хэлний эрэлхэг, зоригтой, хүчтэй баатар гэсэн утга бүхий чур хэмээх үг авч “нусгай чур” (жур) гэжээ хэмээвэл хэтийдсэн санаа болохгүй бизээ.”¹⁸ гээд “... зөвхөн эрэгтэй хүүхдийг нусгай жур. . .”¹⁹ хэмээжээ. Тэгээд “... нусгай жур эртний түрэгийн цолтой шууд холбогдох бөгөөд энэ цол нь хүч чадалтай, эрэлхэг зоригтой буюу ерөөс баатар гэх утгатай асанж”²⁰ гэсэн байна. Мөн Гэсэр хааныг Жур нэртэй байсныг дурдаад “Энэ нь Журийг эгэл жирийн хар тэргүүт хүн бус дэд язгууртай гэсэн санааг илтгэх мэт”²¹ гэжээ. Тэрээр түргийн “чур” цолыг Бодончир нэртэй холбон “... угтаа Бодончур байсныг хэн мэднэ.”²² хэмээн нэн оновчтой санааг дэвшүүлээд “Бодончар аймгийн /боржигид овгийн/ тэргүүн байсны хувьд чур цолтой байх үндэстэй”²³ гэсэн байна. Түрэг судлаач Ц. Баттулгын энэ санааг бүрэн дэмжиж байна. Тэгээд ч сурвалжуудад Бодончир богд²⁴, Мон хан²⁵, эзэн²⁶, гэж тэмдэглэсэн нь дээрх санааг давхар батлаж буй хэрэг юм.

¹¹ “Халх ардын тууль” УБ. 1991 он. 6-р тал

¹² Ш.Гаадамба. “МНТ судлалын зарим асуудал” УБ. 1990 он. 79-р тал

¹³ С.Дулам. “МНТ дахь зүүд зөн совингоор бэлгэдэх ёс уран сайхны дүрслэлийн арга хэрэглүүр болох нь” МНТ-ны 750 жилийн ойд зорилусан ОУ-ын Бага хурал –1. УБ. 1995 он. 234-р тал

¹⁴ Мөн тэнд

¹⁵ С.Харужаубай, Г.Батнасан. Монгол, Түрэг овог аймгийн урианы тухай товч тэмдэглэл. Аман зохиол судлал. УБ. 1987 он. Том XIV Fasc 1-10 256-р тал

¹⁶ Р.Нарантуяа. “Уриахай тууль”. Аман зохиол судлал. УБ. 1987 он. Том XVII Fasc-7 134-р тал

¹⁷ Ю.Болдбаатар. “Шаахарын түрэг бичээс” Алтай судлал-I. УБ. 2001 он.

¹⁸ Ц.Баттулга Чур (сиг) цолын утгыг мөшгих нь. Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг. Боть XV (153) УБ. 2000. 73-р тал

¹⁹ Мөн тэнд

²⁰ Мөн тэнд 74-р тал

²¹ Мөн тэнд

²² Мөн тэнд

²³ Мөн тэнд

²⁴ Лувсанданзан. Алтан товч. УБ. 1990 40-р тал, МНТ 121-р зүйл

²⁵ Д.Гонгор. Халх товчоон. УБ 1970. 70-р тал

²⁶ Г.Гомбожав. Чингис эзний алтан ургийн түүх гангын урсгал нэрт бичиг оршив. УБ. 1992 5-р тал

²⁷ Жү Яотин Чингис хааны түүх шастир. УБ. 2002 15-р тал

²⁸ Гомбожав “Чингис эзний алтан ургийн түүх гангын урсгал нэрт бичиг оршив.” УБ 1992 5-р тал

Хятадын эрдэмтэн Жү Яотин бүтээлдээ "Бодончир" бол түүний өөрийнх нь нэр биш, түүний нэрийг "Мунхаг" гэдэг. "Бодончир" бол түүний алдар цол юм. Хятад хэрээр уггачилбал, "үр хөврөл" гэсэн үг, "дээд өвөг", "уг удам" гэсэнтэй адил. Учир нь түүний хойч үе нь Юань гүрний хаад, тэгээд ч монголын дээд өвөг эцгээр мунхаг өргөмжлөгдсөн агаад түүнийг Бодончир мунхаг хэмээн алдаршуулжээ"²⁹ хэмээн нэн сонин санал дэвшүүлсэн байна. Гэхдээ тэрбээр уг дүгнэлтийг хийхдээ МНТ-д буй "Бодончир" нэрийг галигласан хятад ханз үсгийг уггачлан орчуулсан бололтой. Тэгээд ч Бодончирийн удам Юань гүрэн, Монголын хад болохыг тэр үед мэдэж "дээд өвөг" цол өгсөн нь нэг л үнэмшил муутай. Бас эрдэмтэн Жү Яотин Монголын түүхэнд хандах хятад төвийн үзлээ тусгасан мэт байна.

Бодончир нэрийн ард буй "мунхаг" хэмээх үгийг авч үзье. XVIII зууны үеийн монгол эрдэмтэн Гомбожав "Хүүхэн цагаас угсал номхон ихэмсэг аливаа үйлсийг хэрэгсэлгүй үтээрэхүйд үл ажиглах үгээрэх хэмээнэ Олонхин тэнэг болгон санаад Бодончир мунхаг хэмээн нэрийдэв."³⁰ хэмээн тайлбарласан байдаг. Бидний бодлоор "... Бодончир мунхаг үүр шөнө хагцах мөчид олдсон ба нарааса илүү ухаантай төржээ ..." бие тэрүүтэй, дээл захтай нь сайн"³¹ гэх мэт дэлд гүн утгатай үгийг хэрэглэдэг зэргээс нь үзвэл дотро бодолтой дороо суурьтай нэгэн байжээ.

Эрдэмтэн Г.Сүхбаатар "... мунхаг гэдэг нь мугулюй гэдэгтэй холбогдох нь тодорхой байна."³² гээд "Мугулюй гэдэг угсаатны нэрийг тэмдэглэсэн үг монгол хэлний мухар гэсэн үг байж болмоор байна"³³ гэжээ. Тэгээд "... эрх мэдэлгүй, эрх мэдлийн бэлгэдэлгүй гэдгийг эвэргүй буюу мухар гэдэг байна"³⁴ гэсэн байдаг. Дээрх дүгнэлтүүдээр "Мунхаг"-ийг тайлбарлаж болох мэт. МНТ-нд Бодончирийг эрх мэдэлгүй байхад нь мунхаг хэмээн нэрлэдэг байсан бөгөөд овог тэргүүлэх болсон үеэс нь "мунхаг" гэхээн болж харин хожим үр удам нь "Богд", "Мон хан", "Чингиз", "Эзэн" гэх болжээ.

Судлаач У. Эрдэнэбатын дэвшүүлсэн санаа нь нэлээд сонирхолтой юм. Гэхдээ сүрэг толгойлдог эр гахайд оноосон нэрийн утга нь бүдүүн том бас бусадтай нь харьцуулахад илүү ухаантай байдаг учраас бусдаас нь онцгойлон "Бодон" хэмээн нэрлэсэн байж болох бүрэн үндэстэй. Тэгээд ч монгол хэлэнд бод гэсэн язгуур нь бодож сэтгэх, ухаантай гэсэн утгаас гадна том /бод мал/, мөн бодь хүн, бодь сэтгэл, зэрэг үгс нь тайван уужуу, хүлээцтэй, бодолтой ухаантай гэсэн салаа утгуудыг илэрхийлдэг.

Ингээд дээрх санаануудаа хураангуйлан үзвээс "Бодончир" хэмээх нэр нь бодол ухаантай, баатар хан гэсэн утгатай бөгөөд түүнийг бодол ухаантай хан болохыг бэлэгдэж өгчээ. Харин "Мунхаг" хэмээх дагавар нь "мухар" буюу эрх мэдэлгүй гэсэн утгатай нэмэлт хоч буюу доромж нэр байсан ба хожим боржигон овгийг тэргүүлэх болсон үеэс нь орхигджээ гэсэн саналыг дэвшүүлж байна.

Summary

In the 17th article of Secret History of Mongols there is written the name Bodonchir Munkhag. There are various descriptions and interpretation of this name. I have a hypothesis, that Boorchir the ancestor of Borgigon family, have got this name. The meaning of this name is a wise or hero which symbolizes him as a wise king. Because at that times Mongols had a custom to use foreign words equal to meaning of Mongolian symbolizing the character of the person.

²⁹ А. Энхбат "Бодончир богдын удамыг мөшгөхүй." Угсаатан судлал УБ 2001 196-р тал

³⁰ Г. Сүхбаатар "Монгол-Нирун улс ба Монголын нууц товчоо." МНТ-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал I УБ 1995 28-р тал

³¹ Мөн тэнд 27-р тал

³² Г. Сүхбаатар "Монгол-Нирун улс ба Монголын нууц товчоо." МНТ-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал I УБ 1995 28-р тал